

# Гурав Дахь Мянган Институт

## Дагалдуулалтын Тэмдэг

*Тэр тэдэнд бүгдэд нь хандаж—Хэн нэг нь Миний араас дагахыг хүсвэл тэр нь өдөр бүр өөрийгөө үгүйсгэн, загалмайгаа авч Намайг дага. Хэн амиа аврахыг хүснэ, тэр түүнийгээ алдана. Харин хэн Миний төлөө амиа алдана, тэр түүнийгээ аварна.*

Лук 9:23-24

Христэд итгэгч хүн өдөр бүр Есүсийг дагаж Түүний өгсөн шинэ амьдралдаа өсөж байх учиртай юм. Энэ нь маш олон талтай. Зан чанар өөрчлөн төлөвшиж, Бурханы үгнээс суралцаж, Христийн хайр болон сайнмэдээг бусдад түгээхэд шаардлагатай чадвар хөгжүүлэх гэх мэт олон зүйл үүнд багтдаг. Мөн Есүсийг даруугаар дагаж түүнээс суралцах тусам бид түүнийг гайхан биширч хүндлэх сэтгэлд автдаг нь лавтай. Энэ үйл явцыг бид хамтдаа л мэдэрч хөгждөг. Орон нутгийн онцлог, тухайн нөхцөл байдлын хэрэгцээнээс шалтгаалж дагалдагч болох үйл явц гаднаас харахад өөр өөр байж болох юм. Энэ тэмдэгтийн даалгаварт бүгдээрээ дагалдагч болоход шаардлагатай бүрэлдэхүүнийг хэлэлцэх болно.

### **Тэмдгийн бүрэлдэхүүн хэсгүүд - Хэлэлцүүлэг нь дараах гурван сэдвийг хамруулна:**

**Ахуй соёл** - Амьдарч буй орон нутагтаа дагалдагч болох нь.

**Сүм Чуулган** - Эзэний дуудсан газар дагалдагч болох нь.

**Хувийн** - Бурханы дуудсан хүн болох газраа дагалдагч болох нь

### **Хэлэлцүүлгийн сэдвүүд:**

1. Танай орон нутагт дагалдагч болох үйл явц хэрхэн явагддаг вэ?
2. Бусдыг дагалдуулах үйл явцад ямар гол түлхүүр хэсгүүд нь багтдаг вэ?
3. Хүмүүс Христигэлээр өсөх явцад хүний амьдралд ямар өөрчлөлтүүд гардаг вэ?
4. Дагалдагч болох үйл явц хэрхэн явагдах талаар үлгэр дуурайлал авч болох Библийн ямар эшлэл байдаг вэ?
5. Танай сүм чуулганд дагалдагч бэлтгэх үйл явц хэрхэн явагддаг вэ? Дагалдагч бэлтгэх үйл явцыг дүрсэлсэн бүдүүвч зураг зурна уу?
6. Дагалдагч бэлдэх үйл явцад төвлөрсөн таван эшлэл Библиэс олж жагсааж бичнэ үү.

7. Дагалдагч бэлтгэх хөтөлбөр хөгжүүлэхдээ хүний амьдралын ямар хэсгүүдийг багтаах нь зүйтэй вэ?
8. Есүс Иохан 15-р бүлэг дээр ямар ямар тушаалууд өгсөн бэ?
9. Дагалдагч болох нь хэрхэн зан чанарын төлөвшил болон Ариун Сүнсний Үр Жимс гаргахад нөлөөлдөг вэ?
10. Та нэг дор хэдэн хүнийг дагалдуулах ёстой/боломжтой вэ?
11. Дагалдагч болоход Библи (унших, судлах, цээжилэх нь )ямар үүрэгтэй вэ?
12. Дагалдагч болоход залбирал ямар үр нөлөөтэй вэ?
13. Танай сүм чуулганы удирдлага хөгжил болон дагалдагч бэлтгэх үйл явц хоорондоо хэрхэн холбогддог вэ?
14. Ямар шаардлага хангасан хүн бусдыг дагалдуулж чадах вэ? Та хэн нэгнийг хангалттай удаан дагалдуулсан гэдгээ хэрхэн мэдэх вэ?
15. Дагалдагч бэлтгэх үйл явцад "үг" ба "үйлдэл" -ээ хэрхэн ашиглах ёстой вэ?
16. Дагалдагч нараа зөвхөн дагалдагч байгаад байхын оронд бусдыг дагалдуулахад хэрхэн бэлтгэх вэ?
17. Таныг юу Есүст татагдан түүнд өөрийгөө зориулахад нөлөөлсөн бэ? Та тэр бүхнээ бусдыг дагалдуулахад хэрхэн хослуулах вэ?
18. Таны амьдралд буй гэрийн хүлээсийг юу сулруулж/хүчирхэгжүүлж байдаг вэ?
19. Таныг Христийг эрж хайн дагахад ямар дадал, хэвшил хамгийн их тус болсон бэ?

### **Хэрэгжүүлэх даалгавар:**

1. Өнгөрсөн жилийн турш таныг зан чанарыг хэлбэршүүлэхийн тулд Эзэн таны амьдралд хийсэн бүхий л зүйлийн тухай ярь. Дараа жил Эзэн таны амьдрал юу хийгээсэй гэж хүсэж байгаагаа хуваалц.
2. Таны хамрагддаг сүм чуулган хүмүүсээ дагалдуулахын тулд хийдэг бүх үйл ажиллагааг хуваалц. Бүлгийн хэлэлцүүлгээс ойлгож сурсан зүйл дээрээ үндэслэн өөрийн сүм чуулган, үйлчлэлдээ дагалдагч бэлтгэх төлөвлөгөө зохио. Тэгээд тэр төлөвлөгөөгөө хамгийн сүүлийн хэлэлцүүлгийн цаг дээр бусадтай хуваалцаарай.
3. Хэн нэгэн шинэ итгэгчийг дагалдуулж эхлээрэй.

## **Тэмдэг авах шалгуур:**

Энэ тэмдгийг Суурь Мэдлэгийн Сертификатын бүрэлдэхүүн болгож Гурав Дахь Мянган Институтээс өгдөг. Үүнийг авахын тулд суралцагч **Хэрэгжүүлэх даалгаврыг Тэмдгийн Бүрэлдэхүүн** хэсгүүдийн дагуу хичээлийн явцын турш **Хэлэлцүүлгийн Сэдвүүдийн** хүрээнд чамбай гүйцэтгэсэн байх шаардлагатай.